Эх барихуйн тусламж үйлчилгээнд эмнэлэгт суурилсан төрөлтийн хамтрагчийг хэрэгжүүлсэн үр дүн

П.Цэцэгмаа[1], Ч.Бадамханд[2], Т.Ганчимэг[3]
[1] Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Сувилахуйн Сургууль,
[2] Нийслэлийн Амгалан Амаржих Газар Төрөлжсөн Мэргэшлийн Эмнэлэг,
[3] Япон улсын Цукуба Их Сургууль
Цахим хаяг: tsetsegmaa.p@mnums.edu.mn
Утас: 99959009

Түлхүүр үг:
Доула, төрөх үеийн дэмжлэг, төрөлтийн эерэг туршлага, сэтгэл ханамж

ТОВЧ УТГА:
Эмэгтэй бүр төрөлтөнд бие болон сэтгэлзүйгээ бэлтгэдэг ч хувь хүний мэдлэг, туршлага, бие махбодын онцлог, тухайн төрөлтийн явц, орчин нөхцөл, тусламж дэмжлэгээс шалтгаалан урьдчилан төсөөлж байснаар эсвэл огт өөрөөр ч явагдаж болох юм. Төрөгч эмэгтэй төрөлтийн туршид хэн нэгэнтэй хамт байж, байнгын дэмжлэг авах эрхтэй. Энэ дэмжлэгийг үзүүлэх төрөлтийн хамтрагч нь нөхөр, хамтран амьдрагч, гэр бүлийн гишүүн, хамаатан садан, эмэгтэй найз, эрүүл мэндийн ажилтан, оюутан, доула, уламжлалт төрөлтийн туслагч, эмэгтэйчүүдэд чиглэсэн нийгэмлэг нөхөрлөлийн гишүүн гэх мэт хэн ч байж болно. Бид төрөлтийн хамтрагчийн тасралтгүй дэмжлэгийг Амгалан амаржих газарт нэвтрүүлж, үр дүнг судлах зорилт тавьсан. Бидний судалгаагаар төрөх өрөөнд 2, төрөхийн өмнөх өрөөнд 4 хүртэл төрөгч эмэгтэйн дунд нэг төрөлтийн хамтрагчийг ажиллуулж, үр дүнг судалж байгаагаараа онцлог юм. Энэхүү чанарын судалгаанд хагас бүтцэт ярилцлагын аргаар 81 эхийг хамруулан, судалгааны өгөгдөлд агуулгын дүн шинжилгээ хийсэн. Ярилцлагаар эхчүүдийн өмнөх болон одоогийн төрөлтийн түүх, төрөлтийн явцын тухай, төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн дэмжлэгийн талаарх сэтгэгдэл, юунд илүү сэтгэл ханамжтай байсан, эхчүүдийн санал хүсэлт зэрэг 5 бүлэг мэдээллийг ярилцлагын удирдамжийн дагуу хагас бүтэцлэгдсэн 14 асуумжаар чиглүүлэн ярилцаж, мэдээлэл цуглуулсан. Бид харилцан ярилцлагын илэрхий агуулгыг бодитой, системтэй, тоон байдлаар тодорхойлдог агуулгын дүн шинжилгээний аргыг хэрэглэж, ярилцлагын өгөгдлийн онцгой шинж чанарыг тогтоосон. Ярилцлага бүрийг үгийн утгын дагуу текст болгон хуулбарлан бичсэн. Ярилцлагын текстийн ил болон далд утгыг хоёуланг нь харгалзан судалгааны асуумжийн агуулгыг илэрхийлэх тодорхой үгээр кодлосон. Бүх өгөгдлийг дахин давтан унших замаар текстийг гараар кодлосон болно. Кодлох явцад категориудыг нэмэх уян хатан бодлогыг барьж, давтамжаас илүү үзэл баримтлалын оршихуйд анхаарлаа хандуулж, ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон. Судалгааны ажил эхлүүлэх ёс зүйн зөвшөөр (2019/3-09)-лийг АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооноос авсан. Судалгааны үр дүнгээс харахад төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн биеийн болон сэтгэлзүйн дэмжлэг, мэдээлэл, зөвлөгөө, харилцаа хандлагад бүх эхчүүдийн 77 (95.1%) нь маш сэтгэл хангалуун байсан ба өвдөлтийг даван туулах, тайван ганцаардахгүй байх нөхцөлийг хангасан гэж дүгнэсэн. Ярилцлагын үед ус шингэн уух, хэрэгцээт зүйлсээ авах, бие засах, живхээ солих, өвдөлтийн үед иллэг хийх, бөмбөг дээр суух, хамт алхах болон байнга байж асрах зэрэг биеийн дэмжлэгүүд хамгийн их таалагдсан гэж ээжүүд дурьдсан байна. Харин сэтгэлзүйн дэмжлэгт элдэг харилцан тэдний хэрэгцээ, хүслийг асуух, биелүүлэх; урамшуулах, тайтгаруулах, хамт ярилцах зэрэг нь их таашаагдснаа хэлсэн байлаа. Иймд эмэгтэйчүүд

илүү их энэрэнгүй, анхаарал халамжтай, чин сэтгэлээсээ ханддаг хүнээр дэмжүүлэхийг хүсдэг ба энэ нь тэдний сэтгэлд хүрч, эерэг тааламжтай байдлыг үүсгэдэг нь илэрхий байна. Эхчүүд 100 хувь санал нэгтэйгээр төрөхийн практикт төрөлтийн хамтрагч чухал хэрэгтэйг илэрхийлсэн бөгөөд энэ нь сургагдсан хүн байх нь илүү болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл, төрөлтийн хамтрагч нь төрөлтийн үед зайлшгүй байх ёстой хүний нэг гэж үзсэн бөгөөд туршлагатай зөвлөгч, эерэг хандлагатай, найдвартай туслагч болох нь нотлогдож байна. Судалгаагаар төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн бие болон сэтгэлзүйн дэмжлэгт эхчүүд сэтгэл ханамжтай байсан ба энэ нь цаашид практикт нэвтрүүлэх хэрэгцээ байгааг харууллаа.

ҮНДЭСЛЭЛ:

Төрөх үе нь эх, нярайн эсэн мэнд амаржихад нэн чухал шийдвэрлэх мөч юм. ДЭМБ-ын 2018 оны удирдамжид эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, эх хүүхдийн эрүүл мэнд, эхчүүдийн төрөлтийн эерэг туршлагыг сайжруулахад төрөх үеийн тасралтгүй дэмжлэг чухал болохыг тэмдэглэсэн.[1] Төрөх үеийн тасралтгүй дэмжлэг нь төрөлтийн бүхий л үеийн туршид төрөгч эхийн дэргэд хэн нэгэн буюу төрөлтийн хамтрагч байж, эхэд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, төрөлтийн явцын тухай мэдээлэх, зөвлөх, тайтгаруулах, төрөх үеийн өвдөлтийг бууруулах, тайвшруулах биеийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн эмэгтэйн шийдвэр гаргалтанд туслах зэрэг цогц үйл ажиллагаа юм.[2,3]

Дэлхийн 16 оронд 15288 эмэгтэйг хамруулсан төрөх үеийн тасралтгүй дэмжлэгийн талаарх 22 туршилт-хяналтын судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан Кохрен тойм өгүүлэлд кесар хагалгаа 39%, өвдөлт намдаах эмийн хэрэглээ 10%, нярайн 5 минутын Апгарын үнэлгээ буурах эрсдэл 38%, төрөлтийн үеийн сэтгэл ханамжгүй байдал 31%-иар тус тус буурсан ба төрөлтийн үргэлжлэх хугацаа 41 минутаар богиносон хэвийн төрөлт 15%-иар нэмэгдсэн байгааг харуулжээ. Түүнчлэн тус дэмжлэгийн талаар ямар ч сөрөг үр дагавар тэмдэглэгдээгүй байна.[4]

2018 онд гарсан ДЭМБ-ын “Төрөлтийн эерэг туршлагыг сайжруулахад чиглэсэн төрөх үеийн тусламж, үйлчилгээ” удирдамж болон Төрөлтийн Тусламжийг Дэмжигч Олон Улсын Эвслийн “Эх Хүүхэд-Гэр бүлд ээлтэй, хүндэтгэлтэй эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлэх 12 алхам” зэрэг баримт бичгүүдэд төрөлтийн бүх үеийн туршид эх бүр өөрийн сонгосон хамтрагчтай байхыг зөвлөсөн.[1,5] Төрөлтийн хамтрагч нь эмэгтэйн сонгосон хэн нэгэн хүн байх (нөхөр/хамтран амьдрагч, эмэгтэй найз, хамаатан садан, эрүүл мэндийн ажилтан, уламжлалт төрөлтийн туслагч гэх мэт), эсвэл доула (төрөлтийн дэмжлэг үзүүлэгчээр сургагдсан эмэгтэй) байж болно.[1] Судалгаануудын материалаас үзэхэд сургагдаж мэргэшсэн төрөлтийн хамтрагч буюу доулагийн үзүүлэх төрөх үеийн тасралтгүй дэмжлэгийн үр дүн нь сургагдаагүй хамтрагчаас илүү болохыг тэмдэглэжээ.[4,6]

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад мэргэшсэн төрөлтийн хамтрагч болох доула нь ганцаарчилсан, төлбөрт тусламжийг үзүүлдэг байна. Харин төрөлт ихтэй, амаржих газрын ачаалал өндөр, багтаамж багатай, хүн амын амжиргааны түвшин доогуур хөгжиж буй орнуудад төрөх үеийн тасралтгүй дэмжлэгийг үзүүлэх боломжит хувилбарыг туршиж практикт нэвтрүүлэх асуудал нэн шаардлагатай байна.[1] Иймээс өөрийн орны нөхцөл байдалд тохирсон хувилбарыг амаржих газарт хэрэгжүүлэхийг зорьлоо.

Судалгааны ажлын зорилго

Сургалтаар төрөлтийн хамтрагчаар бэлтгэгдсэн эх барихын ангийн оюутнаар 2-4 төрөгч эхэд тасралтгүй дэмжлэг үзүүлэх үйл явцыг эмнэлгийн практикт нэвтрүүлж, эхчүүдийн сэтгэл ханамжийг судлах

Материал, арга зүй

Судалгааг АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль болон Амгалан амаржих газар хамтран хэрэгжүүлсэн. Төрөлтийн хамтрагчийн төрөлтийн туршид дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 2019 оны 12 сарын 09-нээс 2020 оны 01 сарын 20 хүртэл 42 хоногийн хугацаанд явагдсан. Амгалан амаржих газрын төрөх тасгийн өрөө болон орны тоог харгалзан нэг ээлжинд 5 буюу нийт 20 оюутан ажлын хуваарийн дагуу өдрийн нэг, шөнийн гурван ээлжээр ажилласан. Тухайлбал: 4 ортой төрөхийн өмнөх өрөө болон 2 ортой төрөх өрөөнд тус бүр нэг оюутан ажиллан судалгааны явцад төрсөн нийт 655 эхэд төрөлтийн тасралтгүй дэмжлэг үзүүлсэн байна. Төрөлтийн хамтрагч эхэд хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөө өгөх, амьсгалын, тайвшруулах, өвдөлт бууруулах эмийн бус арга хэрэглэх, хөдөлгөөн хийх болон байрлалаа өөрчлөхөд туслах зэргээр биеийн дэмжлэг үзүүлэх, эхийн хүссэнээр тусалж дэмжих,

эмэгтэйчүүдийн бие даасан байдал, итгэл үнэмшил, өвдөлт зовиурыг даван туулах дотоод хүч чадлыг нэмэгдүүлэх сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, эхтэй хамт байж ганцаардуулахгүй, аюулгүй байдлыг мэдэрч, анхаарлаа төвлөрүүлэхэд нь туслах зэрэг дэмжлэгийг төрөх тасагт ирсэн цагаас төрсний дараах тасаг руу шилжих хүртэл тасралтгүй үзүүлж байлаа. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаанд төрөлтийн явцад сургагдсан төрөлтийн хамтрагчаас тасралтгүй дэмжлэгтэй төрсөн эхчүүдийн сэтгэл ханамжийн судалгааг ганцаарчилсан, хагас бүтцэт ярилцлагын аргаар явуулсан.

Түүврийн хэмжээ, түүвэрлэлт

Судалгаанд оролцогсдын шалгуур үзүүлэлтүүд: Хэвийн төрсөн, эх болон хүүхэд эрүүл, төрөх тасагт 4-өөс дээш цаг байсан, төрөлтийн тасралтгүй дэмжлэг авсан, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн 422 эхээс 81 эхийг зорилтот түүврийн аргаар хамруулан төрсний дараах эхний 24 цаг дотор удирдамжийн дагуу ярилцлагыг дуу хураагч ашиглан бичлэг хийж, тэмдэглэл хөтлөн явуулсан.

Судалгааны хэрэгсэл

Ярилцлагаар эхчүүдийн өмнөх болон одоогийн төрөлтийн түүх, төрөлтийн явцын тухай, төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн дэмжлэгийн талаарх сэтгэгдэл, юунд илүү сэтгэл ханамжтай байсан, эхчүүдийн санал хүсэлт зэрэг 5 бүлэг мэдээллийг ярилцлагын удирдамжийн дагуу хагас бүтэцлэгдсэн 14 асуумжаар чиглүүлэн ярилцаж, мэдээлэл цуглуулсан.

Судалгааны аргачлал

Бид харилцан ярилцлагын илэрхий агуулгыг бодитой, системтэй, тоон байдлаар тодорхойлдог[7] агуулгын дүн шинжилгээний аргыг хэрэглэж, ярилцлагын өгөгдлийн онцгой шинж чанарыг тогтоосон.[8] Ярилцлага бүрийг үгийн утгын дагуу текст болгон хуулбарлан бичсэн. Ярилцлагын текстийн ил болон далд утгыг хоёуланг нь харгалзан судалгааны асуумжийн агуулгыг илэрхийлэх тодорхой үгээр кодлосон. Бүх өгөгдлийг дахин давтан унших замаар текстийг гараар кодлосон болно. Кодлох явцад категориудыг нэмэх уян хатан бодлогыг барьж, давтамжаас илүү үзэл баримтлалын оршихуйд анхаарлаа хандуулж, ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон.

Судалгааны үр дүн

Эхчүүдийн сэтгэл ханамжийн чанарын судалгааны үр дүн: Судалгаанд 21-43 насны (28.6±6.1) 81 эхчүүд оролцсоноос 30 (37%) нь анхан төрөгч байв. Дийлэнх нь давтан төрөгч байсан бөгөөд өмнөх төрөлтөөс энэ удаагийн төрөлтийн үеийн тусламж үнэхээр өөр байсныг сэтгэл хөдлөлтэйгөөр ярьсан байлаа.

Код 1004. “…Урьд нь бол 9 жилийн өмнө төрсөн. Одоо бол тэнгэр газар шиг л өөр байна. Үйлчилгээ нь бас төрөлтийн хамтрагч нь оюутнууд болохоор, цаашдаа энэ мэргэжлийг эзэмших болохооор их хөөрхөн байсан.”

Код 1006. “…Хувийн эмнэлэгт байгаа юм шиг л байна лээ. Ээжүүдэд их хэрэгтэй юм байна лээ.”

Код 1032. “…Өмнө нь бол 3 төрж байхад хажууд тийм зүйл огт байдаггүй байсан. Яг өвдөж байх үед нуруу илээд л их түшигтэй, өвдөлт намдаад байгаа юм шиг тийм мэдрэмж төрсөн.”

Төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн биеийн болон сэтгэлзүйн дэмжлэг, мэдээлэл, зөвлөгөө, харилцаа хандлагад бүх эхчүүдийн 4 (4.9%) нь сэтгэл ханамжтай, 77 (95.1%) нь маш сэтгэл хангалуун байсан ба өвдөлтийг даван туулах, тайван ганцаардахгүй байх нөхцөлийг хангасан гэж дүгнэсэн.

Код 1063. “…Төрөлтийн хамтрагч их сайхан ааштай ээж шиг минь энгэр дээрээ наагаад бүх талаар туслаад яг гэр бүлийн хүн шиг хоол цай өгөөд бүр үнэхээр сайхан байсан. Бүр баярласандаа уйлсан.”

Код 1003. “…Өмнө нь бол 2 төрсөн. Энэ удаагийнх бол 3 дахь нь, энэ удаагийнх нь их гоё санагдсан. Би их азтай төрлөө. Сэтгэгдэл бол бүр 200 хувь байна.”

Код 1031. “…Ёстой гоё юм байна лээ. Хажууд хүн байхаар жаахан ч гэсэн нэмэртэй өвдөлтөө мартаад, хэвтэж байхад нуруу илж өгөөд амьсгаагаа аваарай, гаргаарай, хүчтэй тэгэж болохгүй, бөмбөгөн дээр суувал ингэдэг тэгдэг гээд гоё санагдсан.”

Ярилцлагын үед дараах биеийн дэмжлэгүүд хамгийн их таалагдсан гэж ээжүүд дурьдсан байна. Үүнд: Ус шингэн уух, хэрэгцээт зүйлсээ авах, бие засах, живхээ солих, өвдөлтийн үед иллэг хийх, бөмбөг дээр суух, хамт алхах болон байнга байж асрах гэх мэт. Харин сэтгэлзүйн дэмжлэгт эелдэг харилцан тэдний хэрэгцээ, хүслийг асуух, биелүүлэх; урамшуулах, тайтгаруулах, хамт ярилцах зэрэг нь их таашаагдснаа хэлсэн байлаа. Эхчүүд санал нэгтэйгээр төрөхийн практикт төрөлтийн хамтрагч чухал хэрэгтэйг илэрхийлсэн бөгөөд 65 (80.2%) нь маш чухал гэжээ.

Код 1027. “…Үнэхээр босож чадахгүй, авмаар санагдсан ч авч чадахгүй байх үед сэтгэлээрээ хүний нүдийг уншина гэж байдаг яг тэгж та ингэх үү тэгэх үү гээд, би энийг чинь аваад өгөх үү гээд тэгэх үед гоё байдаг юм байна лээ. Бүр хөөх энэ ингээд байнга байж байдаг бол гэж бодогдохоор байсан.”

Код 1058. ”… Төрөх эмнэлгүүдэд маш хэрэгтэй санагдсан. Эмнэлэг болгонд байвал, бүр ажлын байр болговол бүх ээжүүдэд хэрэгтэй санагдсан.”

Код 1047. “…Маш хэрэгтэй зүйл байна гэсэн бодол анх орж ирсэн цагаас л төрж байсан. Монгол улс даяар хэрэгжвэл их зүгээр. Дан ганц массаж гэлтгүй сэтгэлзүйн хувьд их том дэмжлэг болж байсан. Бүх зүйлд маш их хэрэг болж байсан.”

Код 1002. “…Заавал байх ёстой юм байна гэж санагдлаа. Анхны төрөлт болоод ч тэр үү, их түшигтэй ханьтай байдаг юм байна. Ганцаараа төрвөл өвдөлтөө бүр их мэдрэнэ гэж бодлоо. Тиймээс маш их хэрэгтэй.”

Хамтрагч нь цаашид хэн байж болох талаар тэдний саналыг асуухад 40% нь орон тооны сургагдсан эмнэлгийн ажилтан, 40% нь хүмүүс хоорондын харилцаа хандлага эх болон оюутны аль алинд хэрэгцээтэй байдлаараа сургагдсан оюутан, харин 11% нь дээрх хоёрын аль нь ч байсан болно гэсэн бол 5% нь сургагдсан хэн ч байсан болно гэжээ. Өөрөөр хэлбэл, ээжүүд сургагдсан хүн байх нь илүү болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Өөрийн дотно хүн нөхөр хажууд байж болох ч яах ёстойг мэддэггүй учир туслахаасаа сандрах, бухимдах нь их байна гэж үзжээ.

Код 1027. “…Мэргэжлийн хүмүүс гэдэг чинь нөхрүүдээс шал өөр. Нөхрүүд бол дагаад хамт сандраад байдаг.”

Код 1030. “…Би яг жил дараллан төрж байгаа болохоор өмнөх онд нөхөртэйгөө вип өрөөнд орж байсан. Тэгэхэд бол нөхөр хажууд байгаа ч гэсэн ам цангах ч юмуу хэрэгтэй үед сэтгэлд хүрэхээр биш байсан. Харин төрөлтийн хамтрагч болохоор нуруу илэх үү, яах уу гээд яг сэтгэлд нийцэхээр байсан.”

Код 1080. “…Өвдөөд байж байхад юу хийхээ мэддэг яг яах ёстой, аль газар нь дарах ёстой гээд гэр бүлийнхэн бол яг яах учраа мэддэггүй. Сурч мэдсэн мэргэжлийн хүмүүс бол илүү дээр санагдсан.”

Бид өөрсдийн нөхцөл байдалд зохицуулан 2-4 төрөгч эмэгтэйн дунд нэг төрөлтийн хамтрагч оюутан байхаар төлөвлөж ажиллуулсан ба энэ нь хэр тохиромжтой байгаа талаар ярилцахад ихэнхдээ 2-3 хүний дунд нэг төрөлтийн хамтрагч ажилласан байна. Ээжүүдийн 21 (25.9%) нь төрөлтийн хамтрагч нь байнга хамт байсан гэсэн бол 48 (59.3%) нь хангалттай цаг зарцуулсан гэж үзжээ. Үлдсэн хувь нь байнга зөвхөн өөрийн хажууд байлгахыг хүсч байсан байна.

Код 1073. “…аймар хэрэгтэй, нэмэртэй, ганцаардахгүй зүгээр санагдсан. Ядаж 2 хүний дунд 1 байвал зүгээр санагдсан”

Код 1070. “…төрөлтийн хамтрагч маань өөр хүн үзүүлэх гээд явсан үед ганцаардаад хэцүү байсан”

Код 1075. “…сайжруулаад цаашдаа байвал хэрэгтэй санагдсан. 1 хүнд 1 баймаар санагдсан”

Хэлцэмж: Бусад улс оронд нэг төрөгч эмэгтэйд нэг төрөлтийн хамтрагчийг байлцуулдаг бөгөөд энэ нь олон талаараа үр дүнтэй болох нь судалгаагаар нотлогдсоор байна. Бидний судалгаагаар төрөх өрөөнд 2, төрөхийн өмнөх өрөөнд 4 хүртэл төрөгч эмэгтэйн дунд нэг төрөлтийн хамтрагчийг ажиллуулж, үр дүнг судалж байгаагаараа онцлог юм.

Нэгэн судалгаанд доула буюу сургагдсан төрөлтийн хамтрагчийг эвлүүлдэг тоглоомын алга болсон хэсэгтэй зүйрлэжээ. Өөрөөр хэлбэл, доула нь төрөлтийн үед зайлшгүй байх ёстой хүний нэг гэж үзсэн бөгөөд туршлагатай зөвлөгч, эерэг хандлагатай, найдвартай туслагч[9] гэсэн нь манай судалгаатай тохирч байна. Төрөгч эмэгтэйтэй ойр дотно харилцаатай хүнээс илүү доула төрөлтийн тасралтгүй дэмжлэг үзүүлэх нь төрөлтийн эерэг туршлагыг бий болгоход илүү үр дүнтэй байсан болох нь системчилсэн тойм судалгааны өгүүллийн үр дүнгээс харагдаж байна.[10] Энэ нь тодорхой хэмжээгээр сургагдсан, дадлага туршлагатай хамтрагч байх шаардлагатайг харуулж байна.[4,6] Мөн эмэгтэйчүүд илүү их энэрэнгүй, анхаарал халамжтай, чин сэтгэлээсээ ханддаг хүнээр дэмжүүлэхийг хүсдэг[11] ба энэ нь тэдний сэтгэлд хүрч, эерэг тааламжтай байдлыг үүсгэдэг нь илэрхий байна. Хүүхэд төрүүлэхтэй холбоотой өвдөлт намдаах арга хэмжээ нь нурууны иллэг, гараа барих, амьсгалах аргыг багтаасан янз бүрийн арга техникийг эмэгтэй хүний хэрэгцээ, сонголтоос хамааруулан хэрэглэхэд эмэгтэйчүүдийн бие махбодийн хэрэгцээ хангагдаж[12], тайвшрах, өвдөлтийн мэдрэмж буурдаг нь ажиглагдсан. Ялангуяа өвдөлтийн үед нуруунд иллэг хийх, бөмбөгөн дээр суух, зөв амьсгалах нь илүү үр дүнтэй болох нь бидний судалгааны дүнгээс харагдаж байна.

2018 онд Кени улсад хийсэн судалгаагаар эмэгтэйчүүдийн 18% нь төрөлтийн 1-р үед, 63% нь төрөлтийн 2-р үед хувийн нууцтай холбоотой, хамтрагчдаа үл итгэх, ичих, хүчирхийлэл, хов живээс айх зэрэг шалтгаанаас хамтрагчтай байхаас татгалзсан байна.[13] Манай судалгаанд төрөлтийн хамтрагчтай байхаас татгалзсан тохиолдол гараагүй. Энэ нь оюутнуудын сургагдсан байдал, чин сэтгэл, зүтгэл, хайр халамжийн илрэлтэй холбоотой байж болох юм. Жишээ нь: “… Хэрэгтэй байлгүй яахав одоо надтай төрсөн хүмүүс хүртэл ёстой аятайхан юм байна лээ гээд л тэгж байна. Яг ажилчид чинь болохоор зүгээр зүгээр, битгий муухай чанга орилоод бай, битгий юм цохиод бай гээд хүмүүсийг чинь загнаад л нөгөө дөжирчихдөг байхгүй юу бүр байсаар байгаад, оюутнууд бол аягүй идэвхтэй байгаа байхгүй юу тэд нар чинь ...”. Тиймээс төрөлтийн хамтрагчийг сургаж бэлтгэх, практикт хэрэгжүүлэхэд сургалт, эмнэлгийн байгууллагын оролцоо чухал[1,13] болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Судалгаагаар төрөлтийн хамтрагчийн үзүүлсэн бие болон сэтгэлзүйн дэмжлэгт эхчүүд сэтгэл ханамжтай байсан ба энэ нь практикт нэвтрүүлэх хэрэгцээ байгааг харууллаа. Цаашид төрөх үеийн тасралтгүй дэмжлэгийг бүх шатны амаржих газруудад хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрд ажиллаж буй мэргэжилтнүүдийн дэмжлэг, хүчин чармайлт илүү шаардлагатай байна.

Талархал

Судалгаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Япон улсын засгийн газрын Шинжлэх ухааныг дэмжих тэтгэлэг (JSPS KAKENHI (grant number 19K19637)) болон судалгааг явуулахад гүн туслалцаа үзүүлсэн АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, Амгалан амаржих газар, Япон улсын Цукуба Их сургуулийн удирдлага, хамт олон, төрөлтийн хамтрагч оюутнууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ:

1. *World Health Organization. World Health Organization recommendations: intrapartum care for a positive childbirth experience. Geneva: World Health Organization. 2018. Licence: CC BY-NC-SA 3.0 IGO.*
2. *Цэцэгмаа П, Ганчимэг Т, Сарангэрэл Д. Төрөлтийн хамтрагчийн гарын авлага. Анхдугаар хэвлэл. Улаанбаатар хот: Супер Шийдэл; 2020.*
3. *Hodnett ED. Caregiver support for women during childbirth. Cochrane Database of Systematic Review. 2002 Jan 21.*
4. *Bohren MA, Hofmeyr GJ, Sakala C, Fukuzawa RK, Cuthbert A. Continuous support for women during childbirth. Cochrane Database of Systematic Review. 2017; John Wiley & Sons, Ltd. 1-169.*
5. *Төрөлтийн Тусламжийг Дэмжигч Олон Улсын Эвсэл. Эх Хүүхэд-Гэр бүлд ээлтэй, хүндэтгэлтэй эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлэх 12 алхам. Албан ёсны орчуулга. Улаанбаатар хот: Супер Шийдэл; 2020.*
6. *Taheri M, Takian A, Taghizadeh Z, Jafari N, Sarafraz N. Creating a positive perception of childbirth experience: systematic review and meta-analysis of prenatal and intrapartum interventions. 2018.*
7. *Berelson B. Content analysis in communication research. Free Press. 1952.*
8. *Holsi OR. Content Analysis. In Gardner Lindzey and E.Aronson, eds., Handbook of Social Psychology, Vol 2. Reading, MA: Addison-Wesley, 1968.*
9. *Berg M, Terstad, A. Swedish women’s experiences of doula support during childbirth. Midwifery. 2006; 22: 330–338.*
10. *Hodnett ED, Gates S, Hofmeyr GJ, Sakala C. Continuous support for women during childbirth. Cochrane Database of Systematic Review. 2014.*
11. *Hunter C. Intimate space within institutionalized birth: Women’s experiences birthing with doulas. 2012.*
12. *Kungwimba E, Malata A, Maluwa A, Chirwa E. Experiences of women with support they received from their birth companion during labour and delivery. 2013.*
13. *Afulani P, Kusi C, Kirumbi L, Walker D. Companionship during facility-based childbirth: results from a mixed-methods study with recently delivered women and providers in Kenya. 2018.*

The outcome of implementing labour companionship in midwifery care: A hospital-based study

Tsetsegmaa.P[1], Badamkhand.Ch[2], Ganchimeg.T[3]
[1] School of Nursing, Mongolian National University of Medical Sciences, Mongolia
[2] Amgalan Maternity Specialized Hospital, Ulaanbaatar, Mongolia
[3] University of Tsukuba, Japan
E-mail: tsetsegmaa.p@mnums.edu.mn
Phone number: 99959009

Keywords:
Doula, support during labour and childbirth, positive childbirth experience, satisfaction

ABSTRACT:
Every woman prepares her body and mind for childbirth, but depending on individual knowledge, experience, physical characteristics, the birth process, environment, and medical care, it may go as planned or completely different. A parturient woman has the right to be with someone throughout labour and childbirth and receive continuous support. A labour companionship providing this support can be anyone, such as a husband, partner, family member, relative, female friend, health worker, student, doula, traditional birth attendant, or member of a women’s community. We introduced continuous labour companionship support at Amgalan Maternity Hospital and set out to study outcomes. Our study is unique in that one labour companionship provided continuous support to two parturient women in the delivery room and up to 4 in the labour room and examined outcomes. In this qualitative study, 81 mothers were included through semi-structured interviews, and content analysis was performed on the research data. During the interview, 5 groups of information such as mothers’ previous and current childbirth history, birth progress, impressions of the continuous support provided by the labour companionship, what they were most satisfied with and mothers’ feedback were discussed and collected through 14 semi-structured questionnaires according to the interview guide. We used content analysis methods to objectively, systematically, and quantitatively determine the expressive range of the interviews and identified the unique characteristics of the interview data. Each interview was transcribed verbatim. Taking into account both the explicit and implicit meanings of the interview texts, they were coded with specific words representing the research questionnaire’s content. The text was manually coded by rereading all data. A flexible policy for adding categories was maintained during coding, focusing on concept presence rather than frequency, and general trends were identified. Ethical permission to start research work (2019/3-09) was obtained from the Institutional Review Board of MNUMS. According to the results of the study, 77 (95.1%) of all mothers were very satisfied with the physical and emotional support, information, advice, and communication attitude provided by the labour companionship, and it was concluded that they met the conditions for overcoming pain and not feeling alone. During the interview, mothers mentioned that they liked physical support the most, such as drinking water, getting things they need, going to the toilet, changing diapers, massaging

when they are in pain, sitting on a ball, walking with them, and taking care of them all the time. Also in emotional support, politely asking for and fulfilling their needs and desires, they enjoyed encouraging, comforting and talking together. Therefore, it is clear that women want to be supported by someone who is more compassionate, caring, and sincere, and this affects them and creates positive pleasure. Mothers were 100% unanimous in expressing the importance of labour companionship in their birthing practice and agreed that it was preferable to have a trained person. In other words, labour companionship is considered to be one of the indispensable persons during childbirth and is proven to be an experienced mentor, with a positive attitude and a reliable helper. The study found that mothers were satisfied with the physical and emotional support provided by labour companionship and that this needs to be further implemented in practice.

ЭРДМИЙН ЧУУЛГАН 65

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН САЛБАР ХУРАЛДААН

